

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

... оны ... дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

АВТО ЗОГСООЛЫН ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь авто зогсоолыг төлөвлөх, байгуулах, ашиглах, эзэмших, өмчлөх, хяналт тавихтай холбогдон төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Авто зогсоолын тухай хууль тогтоомж

2.1. Авто зогсоолын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Хот, байгуулалтын тухай хууль², Авто замын тухай хууль³, Барилгын тухай хууль⁴, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, эрх зүйн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “авто зогсоол” гэж авто тээврийн хэрэгслийг байрлуулах, хадгалах зориулалттай, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу байгуулсан, тэмдэг, тэмдэглэгээ бүхий талбай, барилга байгууламж, эсхүл тэдгээрийн хэсэг, дотор болон гадна хэсэгт өргөтгөж, суурилуулсан авто зогсоолын зориулалттай тусгай байгууламжийг;

3.1.2. “авто тээврийн хэрэгсэл” гэж Авто тээврийн тухай хуулийн⁵ 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

3.1.3. “авто тээврийн хэрэгслийг байрлуулах механикжсан төхөөрөмж” гэж авто тээврийн хэрэгслийг механикаар босоо, хэвтээ чиглэлд авто зогсоолд шилжүүлдэг тоног төхөөрөмжийг;

3.1.4. “авто тээврийн хэрэгслийг байрлуулах автоматжуулсан төхөөрөмж” гэж авто тээврийн хэрэгслийг автоматжуулсан төхөөрөмжийн тусламжтайгаар хүний оролцоогүйгээр босоо, хэвтээ чиглэлд авто зогсоолд шилжүүлдэг тоног төхөөрөмжийг;

3.1.5. “авто зогсоол хариуцсан ажилтан” гэж авто зогсоолын хэвийн үйл ажиллагааг хангах, авто зогсоолын зохицуулалтыг хийх, төлбөр хураах зэрэг чиг үүрэгтэй ажилтныг;

3.1.6. “авто зогсоолыг хаах” гэж авто зогсоолын үйл ажиллагааг зогсоохыг;

3.1.7. “дагалдах авто зогсоол” гэж барилга байгууламж (орон сууц, албан газар, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрийн гэх мэт)-ийн дагалдах хэрэгцээний хүрээнд

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Хот байгуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2008 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

³Авто замын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

⁴Барилгын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2016 оны нийтлэгдсэн.

⁵Автотээврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу байгуулсан авто зогсоолыг;

3.1.8. “зам” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн⁶ 2 дугаар зүйлийн 2.1.1-т заасныг;

3.1.9. “зам дагуух авто зогсоол” гэж олон улсын болон улсын, орон нутгийн чанартай замын дагуу болон авто замын зорчих хэсэг дээр хууль тогтоомж, стандарт,-норм, нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу байгуулсан нэмэлт тэмдэг, тэмдэглэгээ бүхий авто зогсоолыг;

3.1.10. “хот, суурин газрын зам дагуух зогсоол” гэж хот суурин газрын төв болон туслах замын дагуу болон авто замын зорчих хэсэг дээр хууль тогтоомж, стандарт,-норм, нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу байгуулсан нэмэлт тэмдэг, тэмдэглэгээ бүхий авто зогсоолыг;

3.1.11. “зам дагуух бус авто зогсоол” гэж энэ хуулийн 3.1.7, 3.1.9-д үл хамаарах хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу тусгайлан тохижуулж байгуулсан авто зогсоолыг;

3.1.12.“нийтийн тээвэр” гэж Авто тээврийн тухай хуулийн⁷ 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасныг;

3.1.13.“нийтийн хэрэгцээний авто зогсоол” гэж аливаа этгээдийн хувьд авто тээврийн хэрэгслээ ямар нэгэн хязгаарлалтгүйгээр байрлуулахад нээлттэй авто зогсоолыг;

3.1.14.“нийтийн хэрэгцээний бус авто зогсоол” гэж тухайн авто зогсоолыг эзэмшигч, эсхүл эзэмшигчийн зөвшөөрлөөр авто тээврийн хэрэгслээ байрлуулах боломжтой зогсоолыг;

3.1.15. “төхөөрөмж бүхий авто зогсоол” гэж жолоочийн тусламжгүйгээр авто тээврийн хэрэгслийг байрлуулах боломжтой барилга байгууламжийн дотор болон гадна тусгайлан суурилуулсан автоматжуулсан, эсхүл механикжсан төхөөрөмжөөр тоноглогдсон авто зогсоолыг;

3.1.16.“хөрөнгө оруулагч” гэж төлөвлөгдсөн байршилд авто зогсоол барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээдийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль нь нийтийн том оврын тээврийн хэрэгслийн болон тусгай үүргийн тээврийн хэрэгслийн зогсоол, түүнчлэн автотээврийн хэрэгсэл зорчигчийг буулгах, суулгах, ачаа ачих, буулгах зурвас, осол, гэмтлийн улмаас зогссон түр зогсоолтой холбогдох талаарх харилцааг зохицуулахгүй.

4.2. Батлан хамгаалах, зэвсэгт хүчний зориулалттай барилга байгууламжийн дагалдах авто зогсоолд энэ хууль хамаарахгүй.

5 дугаар зүйл. Авто зогсоолын талаар баримтлах зарчим

5.1. Авто зогсоолын талаар дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг хангах;

5.1.2. техник, технологийн дэвшлийг ашиглах;

5.1.3.хот, суурины хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан, эдийн засаг, нийгмийн үр ашигтай байх;

⁶Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁷Автотээврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

5.1.4. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд саад учруулахгүй байх, түгжрэлийг сааруулахад чиглэсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Авто зогсоолын талаарх төрийн болон орон нутгийн байгууллагуудын эрх, үүрэг

6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар авто зогсоолын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 6.1.1. авто зогсоолын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- 6.1.2. авто зогсоолын үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх;
- 6.1.3. авто зогсоолын хяналтын дүрмийг батлах;
- 6.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1. зам дагуух авто зогсоолыг төлөвлөх, байгуулах, ашиглах, эзэмших, өмчлөх, хяналт тавихтай холбогдсон дүрэм, журмыг батлах;
- 7.1.2. зам дагуух авто зогсоол байгуулах зөвшөөрөл олгох;
- 7.1.3. зам дагуух авто зогсоолыг төлөвлөхөд орон нутгийн байгууллагад чиглэл өгөх, зам дагуух авто зогсоолын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, дүнг мэдээллэх;
- 7.1.4. зам дагуух авто зогсоолын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг мэдээллэх;
- 7.1.5. төхөөрөмж бүхий авто зогсоол ажиллуулах нийтлэг журам батлах;
- 7.1.6. авто зогсоолын үйл ажиллагаа, техник ашиглалт, тэмдэг тэмдэглэгээний талаар нийтлэг мөрдөх дүрэм, журмыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;
- 7.1.7. төхөөрөмж бүхий авто зогсоол ажиллуулах зөвшөөрөл олгох;
- 7.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.1.1. авто зогсоолын төлөвлөлтийн дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;
- 8.1.2. зам дагуух бус болон дагалдах авто зогсоолын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг мэдээллэх;
- 8.1.3. авто тээврийн хэрэгслийг байрлуулах автоматжуулсан болон механикжсан авто зогсоолын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах, засварлах зөвшөөрөл олгох, хяналт тавих журам батлах;
- 8.1.4. зам дагуух бус болон дагалдах авто зогсоолыг төлөвлөх, байгуулах, ашиглах, эзэмших, өмчлөх, хяналт тавихтай холбогдсон дүрэм, журмыг батлах;
- 8.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

9.1. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад авто зогсоолын төлөвлөлтийн талаар чиглэл өгөх;

9.1.2. орон нутгийн авто зогсоолын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;

9.1.3. авто зогсоолын судалгаа хийх аргачлал, нийтлэг үзүүлэлт, журам, хугацаа, давтамжийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь авто зогсоолын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. энэ хуулийн 7.1.3, 9.1.1-д заасан эрх бүхий этгээдээс өгсөн чиглэлд нийцүүлэн авто зогсоолын төлөвлөгөөг батлах;

10.1.2. хот, суурин газрын **болон орон нутгийн чанартай авто замын** дагуу зогсоолыг байгуулах зөвшөөрөл олгох;

10.1.3. авто зогсоолын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

10.1.4. авто зогсоолын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх;

10.1.5. авто тээврийн хэрэгсэл болон авто зогсоолын төрөл, байршил (аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн бүсчлэл), ойролцоох авто замын ачаалал зэргээс хамааруулж авто зогсоолын төлбөрийн дээд хэмжээг тогтоох;

10.1.6. төлбөртэй авто зогсоол ажиллуулах нийтлэг журам батлах;

10.1.7. авто зогсоол барих газар олгох, авто зогсоолын зураг батлах, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, авто зогсоолыг ашиглалтад оруулах үйл ажиллагааны журмыг батлах;

10.1.8. нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барих, ашиглах нийтлэг журмыг батлах;

10.1.9. хуульд заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

11.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь авто зогсоолын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. авто зогсоолын талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах;

11.1.2. авто зогсоолын төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

11.1.3. авто зогсоолын улсын хяналт хэрэгжүүлэх;

11.1.4. авто зогсоолын нөхцөлийг сайжруулах саналыг жил бүр боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэн шийдвэрлүүлэх;

11.1.5. төлбөртэй авто зогсоол ажиллуулах зөвшөөрөл олгох;

11.1.6. авто зогсоол барих газар олгох, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, авто зогсоолыг ашиглалтад оруулах ажлыг эрх бүхий этгээдтэй хамтран зохион байгуулах;

11.1.7. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан үндэслэлийн дагуу авто зогсоолыг хаах шийдвэрийг гаргах;

11.1.8.авто зогсоолын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
11.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

12.1. Сум, дүүргийн Засаг дарга нь авто зогсоолын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.нутаг дэвсгэрийн авто зогсоолын эрэлт, хэрэгцээний талаарх бодит байдлын судалгааг тогтоосон хуваарь, журам, аргачлал, чиглэлийн дагуу хийж, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай нутаг дэвсгэрийн талаарх саналын хамт аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

12.1.2.авто зогсоолын талаарх хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулах;

12.1.3.авто зогсоол, түүний газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

12.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

12.2.Энэ зүйлийн 12.1.1-д заасан судалгаа, саналыг гаргахдаа харьяалах замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан байгууллагын болон оршин суугчдын саналыг авч тусгасан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Авто зогсоолын ангилал, авто зогсоолд тавигдах нийтлэг шаардлага

13 дугаар зүйл.Авто зогсоолын төрөл, ангилал

13.1.Авто зогсоол нь зам дагуу болон зам дагуу бус, дагалдах гэсэн төрөлтэй байна.

13.2.Авто зогсоол нь нийтийн хэрэгцээний болон нийтийн хэрэгцээний бус гэсэн ангилалтай байна.

13.3.Авто зогсоолын өмчлөгч, эзэмшигч нь тухайн авто зогсоолыг зориулалтын дагуу төлбөртэй болон төлбөргүйгээр, эсхүл хэсэгчлэн болон холимог хэлбэрээр өмчилж, эзэмшинэ.

14 дугаар зүйл.Авто зогсоолд тавигдах нийтлэг шаардлага

14.1.Авто зогсоол дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

14.1.1.хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, тогтоосон норм, дүрэм, стандарт, зураг төслийн дагуу байгуулсан байх;

14.1.2.гудамж, зам, талбай, орчны тохижилттой нийцсэн байх;

14.1.3.тэмдэг, тэмдэглэгээ, хил, хязгаарын зурвастай байх;

14.1.4.авто зогсоолын зогсоол хоорондын зай нь тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх боломжтой байх;

14.1.5.гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй байх;

14.1.6.галын аюулгүй байдлын системтэй байх;

14.1.7.сул чөлөөтэй байгаа зогсоолыг талаарх мэдээллийг үйлчлүүлэгч авах боломжтой байх;

14.1.8.хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто тээврийн хэрэгсэлд зориулсан авто зогсоолын хэсгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1- дүгээр заалтыг хангаж, тогтоосон норм, дүрэм, стандартын дагуу байгуулсан байх;

14.1.9.замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүй байх.

14.2.Авто зогсоолын төрлөөс хамааруулан тусгайлсан шаардлагыг норм, дүрэм, журам, стандартаар тогтоож болно.

14.3.Тэсрэх, түргэн шатамхай, хорт, халдварт, цацраг идэвхит бодис тээвэрлэх болон байлдааны тусгай зориулалттай тээврийн хэрэгслийн авто зогсоолын стандарт, норм, дүрмийг тусгайлан батална.

14.4.Төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч нь авто зогсоолд бусдын авто тээврийн хэрэгслийг төлбөртэйгээр 7 хоногоос дээш хугацаагаар байрлуулан хадгалах тохиолдолд Иргэний хуульд⁸ заасны дагуу гэрээ байгуулна.

14.5.Авто зогсоолын барилгын ажлын техник, технологийн стандарт, норм, дүрмийн хэрэгжилт болон чанарт тавих хяналтыг захиалагч, эсхүл түүнтэй гэрээ байгуулсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

14.6. Батлагдсан зураг төсөлгүй болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хяналтгүйгээр авто зогсоолыг барих ажлыг гүйцэтгэхийг хориглоно.

14.7.Тэмдэг, тэмдэглэгээ, холбогдох тоноглол хийгдээгүй авто зогсоолыг ашиглалтад хүлээн авахгүй.

15 дугаар зүйл. Даатгал

15.1.Төлбөртэй болон төхөөрөмж бүхий авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч нь албан журмын даатгалд заавал даатгуулна.

15.2.Авто зогсоолын аюулгүй байдлыг хангах үүргийг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч бүрэн хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АВТО ЗОГСООЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ

16 дугаар зүйл. Авто зогсоолын эрэлт, хэрэгцээний судалгаа, бүртгэл

16.1. Сум, дүүргийн Засаг дарга нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн авто зогсоолын эрэлт, хэрэгцээний судалгааг энэ хуулийн 9.1.3-т заасан авто зогсоолын судалгаа хийх аргачлалын дагуу хийж, авто зогсоолын хэрэгцээ бүхий нутаг дэвсгэр, замын хөдөлгөөний хэвийн байдлыг алдагдуулж буй авто зогсоолыг тодорхойлж, авто зогсоол шинээр байгуулах буюу авто зогсоолын орчин нөхцөлийг сайжруулах нутаг дэвсгэрийг тогтооно.

16.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ зүйлийн 16.1-д заасан судалгааг явуулах болон авто зогсоол шинээр байгуулах буюу авто зогсоолын орчин нөхцөлийг сайжруулах бүсийг тодорхойлохдоо тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан байгууллагын саналыг авна.

17 дугаар зүйл. Авто зогсоолын төлөвлөлт

17.1. Тухайн нутаг дэвсгэрийн авто зогсоолын төлөвлөгөөг энэ хуулийн 7.1.3, 9.1.1-д заасан эрх бүхий этгээдээс өгсөн чиглэлд нийцүүлэн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

17.2.Энэ зүйлийн 17.1-д заасан төлөвлөгөө нь хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан, энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан судалгаанд үндэслэсэн байна.

⁸Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

17.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн энэ зүйлийн 17.1-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор авто зогсоолыг хөгжүүлэх үе шатны төсөл, хөтөлбөрийг батална.

17.4. Авто зогсоолын төлөвлөгөөг боловсруулах, батлах, өөрчлөх болон биелэгдсэн гэж дүгнэж, үзэж цуцлах тохиолдолд энэ талаар олон нийтэд мэдээлнэ.

17.5. Энэ зүйлийн 17.1-д заасан төлөвлөгөөнд авто зогсоол барих боломжтой газрын байршил, хэмжээг тогтоож, шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоог тусгана.

17.6. Шинээр барих барилга байгууламжийн зураг төсөлд тухайн орон нутгийн хот, суурины төлөвлөлт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, авто зогсоолын эрэлттэй уялдуулан Барилгын тухай хууль тогтоомжид заасны дагуу авто зогсоолыг төлөвлөнө.

17.7. Хот, суурины нягтаршил, газар зохион байгуулалт, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан ажил, үйлчилгээний төвлөрөл, замын хөдөлгөөний эрчим ихтэй хэсэгт болон хүйтний улиралд шаардлагатай дулаан зогсоолын эрэлтийг тооцож авто зогсоолын барилга, байгууламж, эсхүл барилга байгууламжийн дотор авто зогсоолыг байгуулахаар төлөвлөнө.

18 дугаар зүйл. Авто зогсоолын зохицуулалт

18.1. Авто зогсоолын төрөл, ангилал, ерөнхий бүтэц, шаардлага болон төхөөрөмж бүхий авто зогсоолын тоног төхөөрөмж, тэмдэг, тэмдэглэгээнд тавигдах улсын стандартыг стандартчиллын төв байгууллага батална.

18.2. Авто зогсоолын зориулалтын талбай, барилга, байгууламжийн норм, дүрмийг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

18.3. Олон улсын болон улсын чанартай замын дагуу авто зогсоолын байршил, дэд бүтэц, зайлшгүй байх үйлчилгээ, объектыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

18.4. Орон нутгийн чанартай зам, нийтийн эзэмшлийн зам, талбайд авто зогсоол байгуулах байршлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

18.5. Авто зогсоолын зохицуулалтыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн тухайн орон нутгийн сум, дүүргийн Засаг дарга хариуцан хэрэгжүүлнэ.

18.6. Замын хөдөлгөөнд ачаалал үүсгэх авто зогсоолыг байгуулахыг хориглох бөгөөд үйл ажиллагаа явуулж буй авто зогсоол энэхүү нөхцөл байдлыг үүсгэж байвал тухайн авто зогсоолд хөдөлгөөний болон ажиллах цагийн хязгаарлалт хийх зэргээр зүй зохистой ашиглах асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга зохицуулна.

18.7. Авто зогсоолын хэвийн үйл ажиллагааг хангах үүргийг тухайн өмчлөгч, эзэмшигч хүлээнэ.

18.8. Авто зогсоолоос гадуур авто тээврийн хэрэгслийг байрлуулахыг хориглоно.

18.9. Энэ хуулийн 18.8-д заасан хязгаарлалт нь дараах үүргийг хэрэгжүүлж буй тээврийн хэрэгсэлд үл хамаарна:

18.9.1. онцгой байдлын болон нийгмийн хэв журмыг сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа;

18.9.2. эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа;

18.9.3. засвар, барилгын ажил гүйцэтгэх зорилгоор эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авсан нөхцөлд.

ТАВДУГААР БҮЛЭГ

АВТО ЗОГСООЛ ӨМЧЛӨГЧ, ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧИЙН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

19 дүгээр зүйл. Авто зогсоол өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг

19.1. Зам дагуух нийтийн хэрэгцээний авто зогсоол нь орон нутгийн өмч байна.

19.2. Энэ хуулийн 19.1-д зааснаас бусад авто зогсоолын өмчлөгч, эзэмшигч нь энэ хуулийн дагуу өмчлөх, эзэмших эрх бүхий байгууллага, иргэн, хуулийн этгээд, сууц өмчлөгчдийн холбоо байна.

19.3. Зам дагуух нийтийн хэрэгцээний авто зогсоол эзэмшигчийг дараах байдлаар тодорхойлно:

19.3.1. олон улсын болон улсын чанартай авто зам дагуух авто зогсоол эзэмшигч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

19.3.2. нийслэлийн чанартай авто зам дагуух авто зогсоолын эзэмшигч нь нийслэлийн Засаг дарга;

19.3.3. орон нутгийн чанартай авто зам дагуух авто зогсоолын эзэмшигч нь аймгийн Засаг дарга.

19.4. Хөрөнгө оруулагч нь авто зогсоолын барилга байгууламжийн өмчлөгч байх бөгөөд өөрийн өмчлөлийн авто зогсоолыг бусдад худалдан борлуулах эрхтэй.

19.5. Авто зогсоол өмчлөгч, эзэмшигч нь авто замын болон авто зогсоолын талаарх хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх, авто зогсоолыг арчлан хамгаалах, ашиглалтын бэлэн байдлыг хангах, ашиглалтаас хасагдсан тохиолдолд тухайн талбайн нөхөн сэргээх үүрэгтэй.

19.6. Авто зогсоол өмчлөгч, эзэмшигч нь энэ зүйлийн 19.4-т зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

19.6.1. авто зогсоолыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу ашиглалтад хүлээн авах;

19.6.2. авто зогсоолыг засварлах, арчлан хамгаалахад гарах зардлыг санхүүжүүлэх ажлыг зөхион байгуулах;

19.6.3. авто зогсоолд зайлшгүй шаардлагаар орц, гарц, инженерийн шугам сүлжээ байрлуулахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэх;

19.6.4. авто зогсоолд тогтоосон норм, дүрэм, журам, стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээ болон хил хязгаарыг тогтоосон шугам, тоноглол зэргийг байрлуулах;

19.6.5. авто зогсоолыг өөрчлөх, механикжсан авто зогсоолын төхөөрөмжөөр тоноглох тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах;

19.6.6. хуульд заасан бусад эрх, үүрэг.

19.7. Орон сууц, албан газар, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрийн газрын дэргэд автотээврийн хэрэгслийг тусгайлан байрлуулж, хадгалах зориулалттай дагалдах авто зогсоол, талбай, барилга байгууламжийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

20 дугаар зүйл. Авто зогсоол ашиглагчийн эрх, үүрэг

20.1. Авто тээврийн хэрэгслээ байрлуулах, хадгалуулах зорилгоор авто зогсоолыг ашиглаж байгаа этгээд нь авто зогсоол ашиглагч байна.

20.2. Иргэн, хуулийн этгээд нь тухайн авто зогсоолыг ашиглах талаар өөр журам тогтоогоогүй, төлбөртэй талаарх тэмдэг, тэмдэглэгээ байрлуулаагүй нийтийн хэрэгцээний авто зогсоолыг үнэ төлбөргүйгээр ашиглах эрхтэй.

20.3. Авто зогсоол ашиглагч нь дараах эрх, үүрэгтэй:

20.3.1. авто зогсоолыг ашиглахдаа авто замын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, тухайн авто зогсоолын ил байрлуулсан зааврыг дагаж мөрдөх;

20.3.2.авто зогсоол ажиллуулагчийн буруутай үйл ажиллагаанаас өөрт учирсан хохирлыг арилгуулахаар шаардах;

20.3.3.авто зогсоолд бий болсон ноцтой хохирол учруулж болох эвдрэл, зөрчлийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх;

20.3.4.тодорхой бүс нутагт шинээр авто зогсоол бий болгох, эсхүл өөрчлөн сайжруулах талаарх санал, хүсэлтээ холбогдох байгууллагад гаргах;

20.3.5.хуульд заасан бусад эрх, үүрэг.

21 дүгээр зүйл. Авто зогсоолыг ашиглагчид хориглох зүйл

21.1. Авто зогсоол ашиглагч нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1. авто зогсоолын талбай, барилга байгууламжид тээврийн хэрэгсэл байрлуулахаас өөр үйл ажиллагаа явуулах;

21.1.2. авто зогсоолын талбай, барилга байгууламж болон түүнд байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээ, хил, хязгаар тогтоосон тоноглолыг гэмтээх;

21.1.3. авто зогсоолын талбай, барилга байгууламжид гал гаргах, эсхүл түргэн шатамхай болон тэсэрч дэлбэрэх бодис, материал байрлуулах;

21.1.4. авто зогсоолын орц, гарцын хэсэгт хөдөлгөөн хааж, авто тээврийн хэрэгслийг байрлуулах;

21.1.5. авто зогсоолын тогтоосон хил хязгаараас өөр бусад газар зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг байрлуулах;

21.1.6. авто зогсоолд ил байрлуулсан журам, зааврыг зөрчих.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗАМ ДАГУУХ ЗОГСООЛ

22 дугаар зүйл. Зам дагуух зогсоолыг байгуулах

22.1.Энэ хуулийн 19.3-т заасан зам дагуух нийтийн хэрэгцээний авто зогсоолыг эзэмшигч нь батлагдсан зураг төслийн дагуу авто зогсоолыг байгуулах, өөрчлөн сайжруулах ажлыг зохион байгуулж, санхүүжүүлнэ.

22.2. Олон улсын болон улсын чанартай зам дагуух авто зогсоол нь буудал, авто үйлчилгээний төв, шатахуун түгээх станц, цайны газар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын цэг, техникийн засварын цэг, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх цэг, нийтийн бие засах газар зэрэг үйлчилгээний дэд бүтэцтэй байна.

22.3. Зам дагуух нийтийн хэрэгцээний авто зогсоолын барилгын ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу олгоно.

22.4. Зам дагуух авто зогсоолын барилгын ажил гүйцэтгэх болох зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх, **захиалагчийн хяналт тавих** хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна.

22.5. Зам дагуух авто зогсоолыг ашиглалтад хүлээн авахдаа авто замын болон барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад **хэрэгцээ** журмыг баримтална.

22.6. Авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээнд тухайн авто зам, түүний хөдөлгөөний эрчимд тохируулан тогтоосон **стандарт**, норм, дүрэм, журам, стандартын хүрээнд төлбөртэй авто зогсоолыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулж болно.

22.7. Энэ зүйлийн 22.6-д заасан авто зогсоолыг байгуулах, ажиллуулах журам болон төлбөр хураах хэлбэрийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

23 дугаар зүйл. Зам дагуух зогсоолын үйл ажиллагаа

23.1. Зам дагуух авто зогсоол ашигласны төлбөр авч болно. Төлбөрийн хэмжээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон хязгаарын дотор авто зогсоол эзэмшигч тогтооно.

23.2. Зам дагуух авто зогсоол эзэмшигч нь тухайн авто зогсоолын хэвийн үйл ажиллагааг хангах бөгөөд тодорхой этгээдэд авто зогсоол ажиллуулах эрхийг орон нутгийн Хурлаас тогтоосон журмын дагуу шилжүүлж болно.

24 дүгээр зүйл. Зам дагуух зогсоолыг арчлан хамгаалах

24.1. Авто замын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу тухайн авто замын арчлан хамгаалагчаар тогтоогдсон этгээд замын дагуух авто зогсоолын арчлан хамгаалалтыг хариуцна.

24.2. Зам дагуух авто зогсоолын арчлалт, хамгаалалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тасралтгүй байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдал болон авто замын бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс техник, технологийн шаардлагад нийцүүлэн хийнэ.

24.3. Зам дагуух нийтийн хэрэгцээний авто зогсоолыг эзэмшигч жил бүр авто зогсоолын ашиглалтын судалгаа хийх ба судалгаанд үндэслэн авто зогсоолын засвар арчлалтын ажил, түүнд шаардагдах санхүүжилтийг

25 дугаар зүйл. Зам дагуух авто зогсоолыг хаах

25.1. Зам дагуух авто зогсоолыг замын хөдөлгөөнд ачаалал үүсгэсэн, авто замаар хөдөлгөөн үргэлжлүүлэхэд саад учруулсан, эсхүл зам дагуух авто зогсоолыг орлох зам дагуух бус авто зогсоолыг байгуулсан тохиолдолд тухайн авто зогсоол эзэмшигчийн шийдвэрээр хааж болно.

25.2. Зам дагуух авто зогсоолыг хаасан шийдвэр гаргасан тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, бүртгэлд өөрчлөлт оруулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЗАМ ДАГУУХ БУС АВТО ЗОГСООЛ

26 дугаар зүйл. Зам дагуух бус авто зогсоол байгуулах

26.1. Зам дагуух бус авто зогсоолыг байгуулах зөвшөөрлийг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн гаргасан авто зогсоолын төлөвлөгөөний хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан зөвшөөрөл хүсэгч нь хүсэлтдээ авто зогсоол байгуулах зураг төсөл, холбогдох тооцоо судалгааг хавсаргасан байна.

26.3. Зам дагуух бус авто зогсоол байгуулах зорилгоор олгосон газрыг зориулалтын бусаар ашигласан, өөр бусад үйл ажиллагаа эрхлэх барилга байгууламж баривал тухайн газрыг нөхөн олговоргүйгээр буцаан авна.

27 дугаар зүйл. Зам дагуух бус авто зогсоол байгуулах үндэслэл, тооцооллыг гаргах

27.1. Зам дагуух бус авто зогсоолыг байгуулахад хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тухайн газрын нутаг дэвсгэрийн бүсчлэл, хүн ам, үйлдвэр үйлчилгээний газруудын тоо, авто замын хөдөлгөөний эрчим, заын хөдөлгөөний хэвийн байдлыг алдагдуулж буй хүчин зүйлүүдийг тооцолсоны үндсэн дээр төвлөрсөн нийтийн зориулалттай өндөр багтаамж бүхий автозогсоолыг барих үндэслэл, тооцооллыг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулж гаргана.

27.2. зам дагуух бус зогсоолыг 27.1-д заасныг үндэслэн тухайн хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийтийн зориулалттай өндөр багтаамж бүхий автозогссолын төлөвлөлтийг тусгах саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулж аймаг нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулна

28 дугаар зүйл. Зам дагуух бус авто зогсоолын үйл ажиллагаа

28.1. Зам дагуух бус авто зогсоолын үйл ажиллагааг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хариуцан явуулна.

28.2.Зам дагуух бус авто зогсоолын эзэмшигч нь тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга байгаа тохиолдолд авто зогсоол хариуцан ажиллуулагчаар орон нутгийн Хурлаас тогтоосон журмын дагуу гэрээний үндсэн дээр өөр этгээдийг томилж болно.

29 дүгээр зүйл. Зам дагуух бус авто зогсоолыг арчлан хамгаалах

29.1.Зам дагуух бус авто зогсоолын арчлан хамгаалалтыг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хариуцна.

30 дугаар зүйл. Зам дагуух бус авто зогсоолын үйл ажиллагааг түр зогсоох

30.1.Тогтоосон норм, дүрэм, журам, стандартыг зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд зөрчлөө арилгах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга шаардлага тавьж, тодорхой хугацаа өгч, үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргана.

НАЙМДУГААР БҮЛЭГ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДАГАЛДАХ ЗОГСООЛ

31 дүгээр зүйл. Дагалдах авто зогсоол байгуулах

31.1.Авто зогсоолыг хот байгуулалтын талаарх хууль тогтоомжийн болон орон сууц, хороолол, үйлчилгээний байгууллага, албан байгууллага, үйлдвэрийн газрын дагалдах хэрэгцээнд нийцүүлэн холбогдох норм, дүрэм, журам, стандартын дагуу тухайн барилга байгууламжийн гаднах ойр орчмын газар болон дотор байгуулна.

31.2.Дагалдах авто зогсоолын багтаамж, талбайг холбогдох норм, дүрэм, журам, стандартаас гадна авто зогсоолын эрэлт, хэрэгцээнээс хамаарч тогтооно. Үүнтэй холбогдуулан тухайн сум, дүүргийн Засаг дарга тодорхой зохицуулалтыг хийж болно.

31.3.Дагалдах авто зогсоолын талбай тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахгүй байгаагийн улмаас замын хөдөлгөөнд ачаалал бий болж байвал сум, дүүргийн Засаг дарга тухайн барилга байгууламжийн ойролцоо зам дагуух бус болон дагалдах авто зогсоол, авто зогсоолын барилга байгууламж төлөвлөх, барих ажлыг зохион байгуулах, эсхүл ойролцоох эрэлт, хэрэгцээ нь хангагдаагүй авто зогсоолыг ашиглах боломжийг бүрдүүлэх замаар зохицуулалт хийж болно.

31.4.Дагалдах авто зогсоол нь тухайн барилга байгууламжийн эрэлт, хэрэгцээг хангахааргүй байгаа тохиолдолд тухайн байгууламж өмчлөгч, эзэмшигч нь дахин дагалдах авто зогсоол байгуулах, эсхүл тухайн барилга байгууламжийг өргөтгөн холбогдох норм, дүрэм, журам, стандартын дагуу барилга байгууламжийн дотор авто зогсоол байгуулах үүрэгтэй.

31.5. Авто зогсоол байгуулах газар хүрэлцээгүй, байхгүйн улмаас энэ зүйлийн 31.4-т заасан үүргээ дагалдах авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хэрэгжүүлэх боломжгүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр тухайн өмчлөгч, эзэмшигчээс

дагалдах авто зогсоол барих зардлыг гаргуулан ойролцоох газарт авто зогсоол байгуулж болно.

31.6.Энэ хуулийн 31.5-т заасан санхүүжилтээр зам дагуух бус авто зогсоол байгуулах ажлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын үүрэг болгосны дагуу сум, дүүргийн Засаг дарга хариуцна. Энэхүү санхүүжилтийг өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

31.7.Энэ хуулийн 31.5-т заасан зардлыг төлсөн этгээдэд тухайн санхүүжилтийн дагуу байгуулагдсан авто зогсоолыг үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр ашиглуулна.

32 дугаар зүйл. Дагалдах зогсоолын үйл ажиллагаа

32.1.Дагалдах авто зогсоолын үйл ажиллагааг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хариуцан явуулна.

32.2.Дагалдах авто зогсоолыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

32.3.Барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч нь үйлчлүүлэгчдийг дагалдах авто зогсоолыг саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

32.4.Нийтэд худалдаа, үйлчилгээ үзүүлдэг барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь дагалдах авто зогсоолдоо авто зогсоолын зөвөөлын хэвийн үйл ажиллагаа, хөдөлгөөнийг зохицуулах чиг үүрэг бүхий хариуцсан ажилтантай байна.

33 дугаар зүйл. Дагалдах зогсоолыг арчлан хамгаалах

33.1.Дагалдах авто зогсоолын арчлан хамгаалалтыг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хариуцан гүйцэтгэнэ.

33.2.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн оршин суугч, өмчлөгчдөд зориулагдсан авто зогсоол зэрэг барилгын норм, дүрэм, стандартын дагуу баригдсан барилга байгууламжийг арчлан хамгаалах зориулалтаар Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4.1.6-д заасан орчны газрыг сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулах ба тухайн Сууц өмчлөгчдийн холбооноос авто зогсоолын ашиглалт, хамгаалаалтын талаар тодорхой журам тогтоож болно.

33.3.Нийтийн хэрэгцээний, төлбөргүй дагалдах авто зогсоолыг арчлан хамгаалах үүргийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хүлээнэ.

33.4.Зориулалтын бусаар ашигласан, эсхүл ашиглалтын хэвийн нөхцөл алдагдсан дагалдах авто зогсоолын өмчлөгч, эзэмшигчид сум, дүүргийн Засаг дарга дагалдах авто зогсоолын хэвийн ажиллагааг хангуулах талаар шаардлага хүргүүлнэ.

33.5 Энэ зүйлийн 33.4-т заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу торгох, эсхүл авто зогсоолыг хэвийн байдалд оруулахтай холбогдон гарах зардлыг 2 дахин нэмэгдүүлж төлүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТӨХӨӨРӨМЖ БҮХИЙ АВТО ЗОГСООЛ

34 дүгээр зүйл. Төхөөрөмж бүхий авто зогсоол байгуулах, ажиллуулах

34.1.Төхөөрөмж бүхий авто зогсоол байгуулах, эсхүл авто зогсоолд шинээр автотээврийн хэрэгслийг байрлуулах автоматжуулсан, механикжсан төхөөрөмжийг угсарч суурилуулах, засварлахтай холбогдох зөвшөөрлийг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

34.2.Төхөөрөмж бүхий авто зогсоол нь ашиглалтын аюулгүй байдлын батламжтай байна. Ашиглалтын аюулгүй байдлын батламжийг авто зогсоолд ил газар байрлуулна.

34.3.Төхөөрөмж бүхий авто зогсоолын ашиглалт, аюулгүй байдлын баталгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу барилгын улсын байцаагч олгоно.

34.4.Төхөөрөмж бүхий авто зогсоолын ашиглалтын аюулгүй байдлын батламжийн хугацаа дууссан, эсхүл ийм батламжгүй бол уг авто зогсоолыг ашиглахыг хориглоно.

34.5.Төхөөрөмж бүхий авто зогсоолын ажилтан нь тээврийн хэрэгсэл байрлуулах төхөөрөмжийг ажиллуулах болон аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна.

34.6.Төхөөрөмж бүхий авто зогсоолд автотээврийн хэрэгслийг байрлуулах автоматжуулсан, механикжсан төхөөрөмжийг яаралтай унтраах /ослын/ системийг суурилуулна.

35 дугаар зүйл. Төхөөрөмж бүхий авто зогсоолын тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засварлах, салган авах үйл ажиллагаа эрхлэх этгээд

35.1. Төхөөрөмж бүхий авто зогсоолын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, засварлах, салган авах этгээд нь энэ үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Тусгай зөвшөөрлийг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгож, нэгдсэн бүртгэл хөтөлнө.

35.2. Энэ зүйлийн 35.1-д заасан этгээд нь эрх бүхий байгууллагаас тогтоосон хүний нөөцийн болон угсарч суурилуулах, засварлах тоног төхөөрөмжтэй байна.

35.3. Төхөөрөмж бүхий авто зогсоолын тоног төхөөрөмжийн норм, дүрэм, журам, стандарт, түүнийг суурилуулах, засварлах, салгах авах журмыг авто замын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

36 дугаар зүйл. Төхөөрөмж бүхий авто зогсоолыг арчлан хамгаалах

36.1. Төхөөрөмж бүхий авто зогсоолын арчлан хамгаалалтыг өмчлөгч, эзэмшигч этгээд хариуцна.

36.2. Төхөөрөмж бүхий авто зогсоол өмчлөгч, эзэмшигч тогтоосон хугацаанд нь хяналтын үзлэг хийлгэх үүрэгтэй бөгөөд тоног төхөөрөмжийг хэвийн үйл ажиллагааг хангах арчилгааг байнга гүйцэтгэнэ.

36.3. Төхөөрөмж бүхий авто зогсоолын ажилтан нь тоног төхөөрөмжид гарсан эвдрэл, гэмтлийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

37 дугаар зүйл. Төхөөрөмж бүхий авто зогсоолд хяналт тавих, үйл ажиллагааг зогсоох

37.1. Төхөөрөмж бүхий авто зогсоолын үйл ажиллагаанд улсын байцаагч хяналт тавина.

37.2. Дараах тохиолдолд төхөөрөмж бүхий авто зогсоолын үйл ажиллагааг хаах шийдвэрийг улсын байцаагч гаргана:

37.2.1. авто зогсоолын тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан, эсхүл механикаар ажиллах боломжгүй болсон;

37.2.2. тухайн барилга байгууламжийн бүтэц болон аюулгүй байдалд хохирол учруулахаар нөхцөл байдал бий болсон бөд;

37.2.3. хяналтын үзлэг, шалгалтын явцад цаашид ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон бол.

37.3. Энэ зүйлийн 37.2.1-т заасан тохиолдолд улсын байцаагч төхөөрөмж бүхий авто зогсоолын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шийдвэр гаргаж болно. Хэрэв

өгсөн хугацаанд авто зогсоолын хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй бол авто зогсоолыг хаах шийдвэр гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ АВТО ЗОГСООЛЫН ТӨЛБӨР

38 дугаар зүйл. Төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхлэх

38.1.Төлбөртэй авто зогсоолын үйлчилгээг иргэн, хуулийн этгээд эрхэлнэ.

38.2.Төлбөртэй авто зогсоол нь “Төлбөртэй авто зогсоол” гэсэн тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба төлбөрийн талаарх мэдээллийг байрлуулна.

38.3. Төлбөртэй авто зогсоолд дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулна.

38.4. Олон улсын болон улсын чанартай зам дагуу төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

38.5. Орон нутгийн чанартай зам, нийтийн болон хувийн эзэмшлийн зам, талбайд төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхлэх журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

38.6. Төлбөр авах хэлбэрийг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч шийдвэрлэнэ.

39 дүгээр зүйл. Төлбөрийн хэмжээ

39.1. Авто зогсоол өмчлөгч, эзэмшигч нь эрх бүхий байгууллагын тогтоосон төлбөрийн дээд, доод хэмжээнд нийцүүлэн авто зогсоолын төлбөрийн хэмжээг тогтооно.

39.2. Авто зогсоолын ачаалал, авто зогсоолыг үр дүнтэй ашиглах үүднээс авто зогсоолын байршил, авто зогсоол ашигласан цагаас хамааран төлбөрийг харилцан адилгүй тогтоож болно.

39.3. Олон улсын болон улсын чанартай замын дагуу төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхэлснээс олсон орлогыг улсын авто замын санд, орон нутгийн чанартай зам, нийтийн эзэмшлийн зам, талбайд төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхэлснээс олсон орлогыг орон нутгийн авто замын санд төвлөрүүлнэ.

39.4. Хүндэтгэн үзэх шалтгаангүй авто зогсоолын төлбөрийг төлөөгүй тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчид авто зогсоолын төлбөрийг 4 дахин нэмэгдүүлсэнтэй адил хэмжээний торгууль ногдуулна.

39.5. Авто зогсоолд тогтоосон журмын дагуу автотээврийн хэрэгслээ байрлуулаагүй, төлбөрөө төлөөгүй, эсхүл авто зогсоолын орц, гарц, замын зорчих хэсэгт авто тээврийн хэрэгслээ байрлуулсан бол өөр газарт нүүлгэн шилжүүлэх болон хөдөлгөөнийг хязгаарлах төхөөрөмжийг угсарч, үүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

40 дүгээр зүйл. Төлбөртэй авто зогсоолын ажилтан

40.1. Төлбөртэй авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь авто зогсоолын хэвийн үйл ажиллагааг хариуцсан ажилтантай байна.

40.2. Төлбөртэй авто зогсоолын ажилтан авто зогсоолыг ашиглах цагаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тээврийн хэрэгсэл байрлуулахаас татгалзаж болохгүй. Энэ хэсэгт төлбөртэй авто зогсоолын ажилтны эрх, үүргийг тодорхой тусгаж өгөх эсэх

41 дүгээр зүйл. Төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх нөхцөл, журам

41.1. Энэ хуулийн 18.7-д заасан үүргийг хэрэгжүүлж буй авто тээврийн хэрэгслийг авто зогсоолын төлбөрөөс чөлөөлнө.

41.2. Бага оврын буюу хөдөлгүүрийн багтаамж 1500-аас бага болон түлш бага зарцуулах, байгальд ээлтэй автотээврийн хэрэгслийн авто зогсоолын төлбөрийг 50 хүртэл хувиар бууруулж болно.

41.3. Энэ хуулийн 41.2-т зааснаар авто зогсоолын төлбөрийг бууруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

41.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авто зогсоолын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх талаарх зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу зохицуулна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

42 дугаар зүйл. Санхүүжилт

42.1. Зам дагуух авто зогсоол байгуулах болон түүнийг сайжруулах, арчлан хамгаалах ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө хандив, тусламж бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

42.2. Зарим шаардлагатай зам дагуух бус нийтийн хэрэгцээний, эсхүл нийтийн зориулалттай орон сууцны суугчид, өмчлөгчдөд зориулагдсан авто зогсоолыг байгуулах, орчин нөхцөлийг сайжруулах, арчлан хамгаалах ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно.

42.3. Тодорхой нутаг дэвсгэрийн авто зогсоолын орчин нөхцөлийг сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө төвлөрүүлж болно.

42.4. Дагалдах авто зогсоолын санхүүжилтийн асуудлыг тухайн барилга, байгууламж өмчлөгч, эзэмшигч шийдвэрлэнэ.

42.5. Авто зогсоолын орчин нөхцөлийг сайжруулах бүс нутагт хувийн хөрөнгөөр авто зогсоол барих тохиолдолд улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж болно. Энэ тохиолдолд нээлттэй мэдээлнэ.

42.6. Энэ зүйлийн 42.1-42.5-д зааснаас бусад тохиолдолд авто зогсоолын санхүүжилтийг тухайн авто зогсоол өмчлөгч, эзэмшигч хариуцна.

43 дугаар зүйл. Авто зогсоолын хяналт

43.1. Засгийн газар авто зогсоолын хяналтын дүрмийг батлах ба хэрэгжилтийг тухайн орон нутгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

43.2. Замын дагуух авто зогсоол, авто зогсоолын барилга, байгууламж, тэмдэг, тэмдэглэгээнд авто замын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

43.3. Энэ зүйлийн 43.2-т зааснаас бусад авто зогсоолын барилга, байгууламж, авто зогсоолын тоног төхөөрөмж, тэмдэг, тэмдэглэгээнд барилгын техникийн улсын хяналтын байцаагч хяналт тавина.

44 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1. Авто зогсоолын хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч дараах захиргааны шийтгэл ногдуулна:

44.1.1. Энэ хуулийн 17.9, 18.7, 19.3, 20.1-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

44.1.2.энэ хуулийн 16, 32, 36 дугаар зүйл, 13.1, 13.6, 14.1, 14.2, 18.5, 18.6, 30.2-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг дөчөөс наяд дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

44.2.Энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй нь тогтоогдсон бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь хүчингүй болгон, хохирлыг нь нөхөн төлүүлнэ.

44.3.Авто зогсоолын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны шийтгэл ногдуулж, бусдад учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

44.4. Авто зогсоолд байрлуулсан тээврийн хэрэгслээс эд зүйл алдагдсан, эвдрэл гэмтэл гарсан бол авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч байгууллага хариуцлага хүлээнэ.

45 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

45.1. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг